Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2019 оны 47 тоот тушаалын
6 дугаар хавсралт



СТРАТЕГИ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

СТРАТЕГИ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ТАЙЛАНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Гүйцэтгэлийн тайлан иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч, тодорхой байх ёстой.

Иж бүрэн байх гэдэг нь бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайланд тусгагдсан асуудлуудыг зохих ёсоор нь зөв ойлгох болон тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн хэрэгцээтэй бүхий л мэдээллийг тайланд тусгасан, хавсаргасан байхыг хэлнэ.

Алдаа мадаггүй байх гэдэг нь гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зүйл үнэн бодитой, зөв зүйтэй илэрхийлэгдсэн байхыг хэлнэ. Гүйцэтгэлийн тайланд нэг л алдаа мадаг илэрвэл тэр нь бүхий л тайлангийн үнэн бодитой эсэхэд эргэлзэхэд хүргэж, хэрэглэгчдийн анхаарлыг тайлангийн гол агуулгаас хөндийрүүлж болзошгүй юм. Түүнчлэн, алдаа мадагтай тайлан нь уг тайланг гаргасан байгууллагад итгэх итгэлийг сулруулж, тайлангийн үр нөлөөг бууруулах эрсдэлтэй.

Бодитой байх гэдэг нь тайлангийн илэрхийлэл бүхэлдээ агуулга, өнгө аясын хувьд тэнцвэрт харьцааг барьсан байхыг хэлнэ. Тайланд тусгагдсан зүйлийг уншсан хүн өөрийн эрхгүй үнэмших байдлаар ямар нэгэн урьдчилсан байр суурьгүйгээр илэрхийлж чадвал тайланд итгэх итгэл мэдэгдэхүйц дээшилнэ.

Итгэл үнэмшил төрүүлэхүйц байх гэдэг нь гүйцэтгэлийн үр дүн зорилтуудад хариулт болж чадахуйц байх, үр дүнг үнэмшилтэй илэрхийлсэн байх буюу баримтаас урган гарсан байхыг хэлнэ. Ингэж бэлтгэгдсэн тайлан эрх бүхий албан тушаалтнуудын анхаарлыг гол асуудлуудад нь хандуулж, засаж залруулах, арга хэмжээг идэвхижүүлэхэд дөхөм болно.

Тодорхой байх гэдэг нь гүйцэтгэлийн тайланг уншиж, ойлгоход хялбар байхыг хэлнэ. Тайлан нь тухайн сэдвийн боломжоос хамааран аль болох тодорхой бөгөөд энгийн үг хэллэгээр бичигдсэн байх ёстой. Амар хялбар байдлаар илэрхийлэхийн тулд утга санааг шулуухан илтгэсэн, техникийн бус үг хэллэг ашиглах нь чухал. Товчилсон үгийг аль бол бага хэрэглэх нь зүйтэй.

Товч байх гэдэг нь тайлан хэлэх гэсэн зүйлээ бусдад хүргэхээс илүү урт байх ёсгүй гэсэн үг. Хэт их дэлгэрэнгүй мэдээлэл оруулах нь тайлангийн ач холбогдлыг бууруулах, хэлэх гэсэн гол санааг далдлах, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх эрсдэлтэй. Мөн шаардлагагүй бол нэг зүйлийг дахин давтахаас сэргийлэх хэрэгтэй.

ТАЙЛАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Нэг ажил үйлчилгээ, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтааж тайлагнана. Тайлагнахдаа дараах асуудлыг заавал тусгасан байна.

- ✓ Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
- ✓ Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах

Гүйцэтгэлийн тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцдаг байна.

СТРАТЕГИ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Гүйцэтгэлийн мэдээлэл нь байгууллага дотор хэвтээ, босоо аль аль чиглэлд урсаж байх шаардлагатай. Хэвтээ чиглэлд мэдээллээ харилцан хуваалцаж хэрэглэх нь маш чухал. Албан хаагчид өөрсдийн ажиллаж буй байгууллага болон бусад байгууллага ямар мэдээлэл цуглуулж байгааг мэддэг байх хэрэгтэй.

Мэдээллийн чанарын гурвалжин

Мэдээллийн тогтолцоо нь 3 үндсэн шалгуурыг хангах шаардлагатай. Найдвартай, баталгаатай, цаг үеэ олсон байх. Эдгээр шалгуурын аль нэгийг хангаагүй бол тогтолцооны найдвартай байдал алдагдана.

Хяналт-шинжилгээ гэдэг нь стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх үйл ажиллагаа юм.

Үнэлгээ гэдэг нь стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлт юм.

Явцын үнэлгээ гэдэг нь хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагаа юм.

Эцсийн үнэлгээ гэдэг нь стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон, цаашид тухайн чиглэлээр ямар арга хэмжээ хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагаа юм.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэглээ

- ✓ Нөөцийн хуваарилалтын талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх
- ✓ Асуудлын шалтгааныг дахин авч үзэх
- ✓ Шинээр гарч буй асуудлыг тодорхойлох
- ✓ Өрсөлдөх, эсвэл хамгийн оновчтой хувилбарын талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх
- ✓ Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явцад дэмжлэг үзүүлэх
- ✓ Асуудлын шалтгаан болон хэрхэн хариу арга хэмжээ авах талаар санал нэгдэх

ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Удирдлага шийдвэр гаргахад үнэлгээний мэдээлэл дараах дэмжлэгүүдийг үзүүлдэг. Үүнд:

1. Төлөвлөлт болон гүйцэтгэлийн зөрүү. Шалгуур үзүүлэлтийг тогтмол хэмжих явцад төлөвлөлт болон бодит гүйцэтгэлийн хооронд зөрүү их байгаа тохиолдолд үнэлгээний мэдээлэл маш чухал байна. Удирдлага яагаад гэдэг шалтгааныг мэдэх хэрэгтэй.

   - "Юунаас болж бид төлөвлөсөн гүйцэтгэлээс доогуур байна, эсвэл бидний үйл ажиллагаа сайн байгаа учраас төлөвлөснөөсөө илүү байна уу?"

   Удирдлага төлөвлөлт болон бодит гүйцэтгэл ижил байдаггүй бөгөөд заримдаа зөрүү гарч болохыг мэднэ. Гэхдээ, зөрүү маш их, тогтвортой байгаа нөхцөлд эргэн харж, зөрүү гарсан шалтгааныг олж засах, эсхүл сайн гүйцэтгэлийг түргэтгэх эсэхийг шийдвэрлэх шаардлагатай.

2. Үр дүнд төлөвлөлт болон гүйцэтгэлээс оруулах хувь нэмэр. Үнэлгээний мэдээлэл нь үр дүнд төлөвлөлт болон гүйцэтгэлийн оруулж буй хувь нэмрийн ялгааг тодорхойлох явдал.

   2.1. Сайн төлөвлөлт, сайн хэрэгжилт – Хүлээгдэж буй үр дүнд хүрсэн байна. Удирдлагууд, төлөвлөгчид болон хэрэгжүүлэгчид цөм өөрсдийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байна.

   2.2. Сул төлөвлөлт, сайн хэрэгжилт – Үр дүн нь бага буюу огт алга. Үнэлгээний асуулт нь төлөвлөлтөд чиглэнэ.

   - Төлөвлөлт оновчтой байсан уу?
   - Энэ нь хэрэгжилт сайн байсан тохиолдолд хүлээгдэж буй үр дүнг бий болгох уу?
   - Асуудлыг зөв ойлгож, ойлгомжтой тодорхойлж чадсан уу?
   - Санал болгож буй өөрчлөлтийн арга зам нь асуудлын гол шалтгаанд чиглэж чадсан уу?

2.3. Сайн төлөвлөлт, хангалтгүй хэрэгжилт – *Үр дүн нь бага буюу огт алга.* Үнэлгээний асуулт нь хэрэгжилтийн үйл явцад чиглэнэ.

- Хийгдэх ёстой ажлуудыг хийсэн үү?
- Хэзээ, ямар дараалаар хийсэн бэ?
- Ямар хэмжээний дэмжлэг байсан бэ?
- Ажилтнуудын мэдлэг, туршлага ямар байсан бэ?

Гол анхаарах асуудал нь амжилттай хэрэгжиж болох байсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй гэж дүгнэхэд хүргэсэн зүйлээс суралцах явдал юм.

2.4. Сул төлөвлөлт, хангалтгүй хэрэгжилт – *Үр дүнгийн ямар ч ул мөр алга.* Зөвхөн хоосон сайхан санаа л байна. Удирдлагын хувьд энэ ажлыг хурдан зогсоох шаардлагатай.

3. Нөөцийн хуваарилалт. Зорилт, арга хэмжээний нөөцийн хуваарилалт хийх үед үнэлгээний мэдээлэл нь удирдлагуудад юу үр дүнтэй, үр ашигтай хэрэгжих, эсвэл хэрэгжихгүй байгаа талаар дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлдэг.

4. Үр дүнгийн талаарх зөрчилтэй баримт. Үнэлгээний мэдээлэл нь зорилт, арга хэмжээнүүд ижил төстэй боловч өөр өөр үр дүнтэй байх үед чухал юм. Илт тодорхой үр дүн бүхий харьцуулж үзэхүйц зорилт, арга хэмжээний хувьд хаана юу болж байгаа талаар асуулт үргэлж хөндөгдөж байдаг. Үүнд:

- Зөрүүтэй үр дүнд хүргэж буй хэрэгжилтийн явц дахь илэрхий ялгаа байгаа эсэх?
- Эсвэл гол ажилтан нь үйл ажиллагааны үндсэн зорилго, логик үндэслэлийг ойлгоогүйн улмаас ихээхэн өөр чиг хандлагад хүргэх харилцан адилгүй зааварчилгаа, чиглэл өгч байна уу?
- Эсвэл гурав дахь боломж болох тайлагнах арга хэмжээ нь харьцуулалт хийх боломжгүй болтлоо ялгаатай байна уу?

ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

Харилцан адилгүй асуултад хариулт өгөх *"бүгдэд таардаг"* үнэлгээний загвар гэж байхгүй. Удирдлагууд үнэлгээнээс юу олж мэдэхийг хүсч байгаа талаар тодорхой ойлголттой байх нь чухал. Үүний адилаар, үнэлгээний мэдээлэл гаргаж буй ажилтнууд удирдлагад юу хэрэгцээтэй байгааг мэдэж байх хэрэгтэй. Тавьж буй асуулт болон хариулж буй мэдээлэл хоорондоо зөрүүтэй байх нь хэн хэндээ үр ашиггүй.

Үнэлгээний аргачлалууд

Аргачлал №1. Гүйцэтгэлийн логик холбоосыг үнэлэх аргачлал нь төлөвлөлтийн цаад учир шалтгааныг судалдаг. Үнэлгээ нь өмнөх ижил төстэй ажил, судлагдсан байдал зэрэгт үндэслэн төлөвлөж буй зорилт, арга хэмжээ нь хүлээгдэж буй үр дүнд хүрэх магадлалыг авч үздэг. Үнэлгээний зорилго нь муу төлөвлөлтөөс зайлсхийх явдал юм.

Аргачлал №2. Хэрэгжилтийн өмнөх үнэлгээ нь хэрэгжилтийн үе шатанд орохоос өмнө удирдлагын зүгээс нарийвчлан тодруулах 3 стандартыг авч үздэг. Дараах асуултуудад стандартууд багтсан байна.

- Үр дүнг хэмжиж болохуйц байх үүднээс зорилт, арга хэмжээг оновчтой тодорхойлсон уу?
- Хэрэгжилт хэрхэн явагдах, амжилттай хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжилтээс ялгах үндэслэл сайтай, бодитой ажлын төлөвлөгөө байна уу?
- Нөөцийн хуваарилалт нь тодорхойлсон үр дүнд хүрэхэд тавигдах шаардлагыг хангасан уу?

Үнэлгээний зорилго нь хэрэгжилтийн эхнээс л алдаа гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлэх явдал.

Аргачлал №3. Хэрэгжилтийн үнэлгээ нь хэрэгжилтийн асуудалд голчлон анхаардаг.

- Төлөвлөсөн ажлуудаас юу хэрэгжиж, юу хэрэгжсэнгүй вэ?
- Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон бодитойгоор хийгдсэн ажлуудын хооронд зөрүү байна уу?
- Зардал, шаардагдах цаг хугацаа, ажилтнуудын мэдлэг чадвар, хэрэгцээтэй санхүүгийн нөөц, техник хэрэгсэл, мөн улс төрийн дэмжлэгийг төлөвлөгөөнд хэр оновчтой, нарийвчлалтай тусгасан бэ?
- Хэрэгжилтийн үе шатанд урьдчилан тооцоолоогүй (төлөвлөгөөгүй) ямар асуудлууд гарсан бэ?

Анхаарах асуудал нь хэрэгжилтийн үйл явц юм. Удирдлагууд өөрсдийн тодорхойлсон үр дүнд хүрэх явцад засч залруулах зүйл байгаа эсэхийг тогтооход энэ мэдээллийг ашиглана.

Аргачлал №4. Шуурхай үнэлгээ нь тухайн цаг хугацаанд бодит байдлын үнэлгээ хийх бөгөөд тодорхой зорилт, арга хэмжээний явцын талаар шийдвэр гаргагчдыг нэн даруй шинэчилсэн мэдээллээр хангах боломж олгодог. Үнэлгээний мэдээлэл цуглуулах 5 үндсэн арга байдаг.

- Гол мэдээлэл өгөгчтэй ярилцлага хийх
- Зорилтот бүлэгтэй ярилцлага хийх
- Олон нийттэй ярилцлага хийх
- Зохион байгуулалттай шууд ажиглалт
- Санал асуулга.

Шуурхайн үнэлгээ нь албан ёсны, системчилсэн үнэлгээний аргатай харьцуулахад шаардлагатай мэдээллийг түргэн, цаг тухайд нь харьцангуй бага зардлаар боловсруулдаг. Ийм үнэлгээ нь зорилт, арга хэмжээ зөв хэрэгжиж байгаа эсэхийг харуулах шуурхай мэдээлэл бий болгодог. Гэвч хувь хүний үзэл бодол тусгагдах, хялбар батлагдан дахин гаргах боломжтой тоон мэдээлэл хангалтгүй байдаг зэргээс шалтгаалан шуурхай үнэлгээний найдвартай, баталгаатай, үнэмшилтэй эсэх талаарх асуултыг нээлттэй үлдээх хэрэгтэй. Ерөнхийдөө, шуурхай үнэлгээ нь явцын дунд засч залруулах хэрэгцээ байгаа эсэх талаар яаралтай дүгнэлт гаргах боломжийг олгодог.

Аргачлал №5. Нөхцөл байдлыг судалгаа нь зорилт, арга хэмжээний хувьд юу болсон талаар илүү тодорхой ойлголт авахын тулд удирдлагад нарийвчилсан мэдээлэл шаардлагатай үед хэрэглэхэд тохиромжтой үнэлгээний арга юм. Нөхцөл байдлын судалгаанаас удирдлага дараах 6 төрлийн мэдээллийг авах боломжтой.

- Нөхцөл байдлын судалгаа нь илүү ерөнхий байдлыг харуулж чаддаг.
- Тодорхой салбар, эсвэл асуудлын талаар мэдээлэл бага байх үед шинжлэн судалж чаддаг.
- Чухал асуудалд анхаарал тавьдаг (төсөл, хөтөлбөрийн өндөр үр дүн, эсвэл аймшгийн уналт)
- Хэрэгжилтийн үйл явцыг сонгон ул суурьтай хянаж, судалдаг.
- Санаачилгаас бий болсон төсөл, хөтөлбөрийн үр дүнг судалж чаддаг.
- Олон тооны нөхцөл байдлын судалгааг дүгнэж, нэгтгэсэн үед нөхцөл байдлын илүү өргөн хүрээтэй ойлголтоор хангаж чаддаг.

Аргачлал №6. Үр нөлөөний үнэлгээ нь гарч ирсэн өөрчлөлтийг олж, эдгээр нь юуны улмаас бий болсныг тогтоох гэж оролддог (зөвхөн баримт нотолгоо гарсны дараа биш) сонгодог үнэлгээ юм. Үнэлгээ нь баримт мэдээллийн дүнд мэдсэн үр нөлөөний ямар хэсэгт нь хэрэгжүүлсэн арга хэмжээ нөлөөлсөн болон өөр үйл явдал, нөхцөл байдлын дүнд ямар өөрчлөлт гарах байсан гэдгийг тодорхойлохыг зорьдог. Гол зорилго нь баримт нотолгоогоор илрүүлсэн өөрчлөлтийн үндэс, шалтгаан юм. Үнэлгээний энэ хэлбэр нарийн түвэгтэй, ялангуяа хэрэгжүүлсэн арга хэмжээ дуусаны дараа хийхэд хэцүү байдаг (хэрэв үр дүн тодорхой байгаа бол илэрч гарч ирэхэд цаг хугацаа шаардагдсан байгаа). Хэрэгжилт дуусан болон өөрчлөлтийг тодорхойлох оролдлого хоёрын хооронд хугацаа урт байх тусам хүлээгдэж байсан үр дүнд эерэг, эсвэл сөрөг байдлаар өөр бусад хүчин зүйлс хөндлөнгөөс нөлөөлөх магадлал их болох бөгөөд өөрчлөлтийг хэмжихээр төлөвлөсөн цаг хугацааны асуудал мөн алдаатай болж, үр дүн нь бусад шинээр гарч ирж буй нөхцөл байдалд уусан алга болно.

Хамаарлын асуудлыг авч үзэх авч үзэх бас нэг арга бол хэрэв арга хэмжээ аваагүй бол юу болох байсан бэ хэмээн баримт сөргүүлэх, асуудал дэвшүүлэх явдал юм.

Аргачлал №7. “Мета” үнэлгээ нь нэг буюу ижил төстэй санал санаачилгын хувьд хийгдсэн хэд хэдэн үнэлгээг судалж, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа юм. Мөн үнэлгээний ажилтнуудын гүйцэтгэлийн чанарыг үнэлэх, үр дүнгийн үнэлгээнд хийсэн үнэлгээ байдлаар хэрэглэгдэнэ.

“Мета” үнэлгээ нь “Тухайн асуудлын талаар бид юу мэдэж байна, итгэл үнэмшил хэр байна?” гэдгийг мэдэх харьцангуй хурдан арга юм.



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.
ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ

Төрийн жинхэнэ албан хаагч ажлын гүйцэтгэлээ стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах шаардлагыг бүрэн хангаж тайлагнах ёстой.

Хэрэв албан хаагч тайланд тавигдах шаардлагуудыг бүрэн хангаж гүйцэтгэлээ тайлагнаагүй тохиолдолд нэгжийн дарга тухайн арга хэмжээний гүйцэтгэлийг тайлангийн чанар муу гэж үзэн үнэлгээг бууруулна.

Мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайлангаа удаа дараа хугацаа хоцроосон / хоёр ба түүнээс дээш / тохиолдолд нэгжийн дарга нэг удаа сануулж, дараагийн удаа байгууллагын үнэлгээний багт мэдэгдэнэ.



ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХ

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэх арга зүй

“ХАНГАЛТГҮЙ” гэдэг үнэлгээг зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох / сул төлөвлөлт / шаардлагатай, шалгуур үзүүлэлт нь хүрэх түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт муу / хангалтгүй хэрэгжилт /, эсхүл тайланд тавигдах шаардлагын дагуу тайлагнаагүй / тайлангийн чанар муу / тохиолдолд өгнө.

“ХАНГАЛТТАЙ” гэдэг үнэлгээг зорилт, арга хэмжээ нь оновчтой / сайн төлөвлөлт / тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн / сайн хэрэгжилт /, тайланд тавигдах шаардлагын дагуу тайлагнасан / тайлангийн чанар сайн / тохиолдолд өгнө.

Нэгжийн дарга дараах тохиолдолд сул төлөвлөлт гэж үзэн үнэлгээг бууруулна.

- Зорилт, арга хэмжээг стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлох аргачлалд нийцүүлэн төлөвлөгөөгүй;
- Төлөвлөгөө боловсруулахад тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг хангаагүй;
- Шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчлан тодорхойлоогүй;
- Шалгуур үзүүлэлт боловсруулахад гаргадаг нийтлэг алдаа дутагдлыг гаргасан;
- Стратегийн болон гүйцэтгэлийн зорилтууд, гүйцэтгэлийн зорилтууд хоорондын уялдааг хангаагүй;
- Зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангаагүй.

Нэгжийн дарга хангалтгүй хэрэгжилт гэсэн үнэлгээг өгсөн бол албан хаагчтай дараах асуудлаар ярилцан хангалтгүй гэж дүгнэхэд хүргэсэн шалтгааныг тодруулж, цаашид гаргахгүй байх талаар анхаарч ажиллана.

- Хийх ёстой ажлуудаа цагт нь хийсэн үү? Хийгээгүй бол яагаад?
- Хэзээ, ямар дараалаар хийсэн бэ? Холбогдох журам, заавар, аргачлалын дагуу хийсэн үү?
- Ямар хэмжээний дэмжлэг байсан бэ? Дэмжлэг дутагдсан уу?
- Ажилтны мэдлэг, туршлага ямар байсан бэ? Ямар мэдлэг чадвар, дадлага туршлага дутагдав?

№	Тайлангийн төрөл	Тайлагнах албан тушаалтан	Тайлагнах хугацаа	Хүлээн авах албан тушаалтан	Баталгаажуулах, үнэлэх хугацаа
1.	Сарын ажлын гүйцэтгэлийн тайлан	Төрийн жинхэнэ албан хаагч	Сарын ажлын сүүлийн өдөр	Нэгжийн дарга	Дараа сарын 05-ны дотор
2.	Улирлын гүйцэтгэлийн тайлан		Улирлын ажлын сүүлийн өдөр		Дараа улирлын эхний сарын 05-ны дотор
3.	Хагас жилийн гүйцэтгэлийн тайлан		06 сарын 20-ны дотор		06 сарын 25-ны дотор
4.	Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан		12 сарын 14-ны дотор		12 сарын 18-ны дотор

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЗААВАР

САРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ

Төрийн жинхэнэ албан хаагчийн сарын ажлын гүйцэтгэлийн тайлан нь 5 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Тайлангийн агуулга

- Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт
- Шуурхай үүрэг даалгаврын биелэлт
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Хариутай бичгийн шийдвэрлэлт

Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажлын биелэлтийг энэ хэсэгт бичнэ.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

САРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Ажлын чиглэл	№	Хийх ажлын жагсаалт	Ажлын гүйцэтгэл
Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх	1.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
	2.	.....	
Төрийн үйлчилгээг сайжруулах	3.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
	4.	.....	.....
Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	5.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
	6.		.....
	...	.....	.....

Шуурхай үүрэг даалгаврын биелэлт

Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгаруудын биелэлтийг энэ хэсэгт бичнэ.

Хоёр. Шуурхай үүрэг даалгаврын биелэлт / Удирдлагаас, хурлаас болон ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгавар /

Ажлын чиглэл	№	Хийх ажлын жагсаалт	Ажлын гүйцэтгэл	Үнэлгээ
Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх	1.	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар 1 үүрэг даалгаврыг 1000 тэмдэгтэд багтаана. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.	Хангалттай Хангалтгүй
	2.	.....	.....	.....
Төрийн үйлчилгээг сайжруулах	3.	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар 1 үүрэг даалгаврыг 1000 тэмдэгтэд багтаана. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.	Хангалттай Хангалтгүй
	4.	.....	.....	.....
Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	5.	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар 1 үүрэг даалгаврыг 1000 тэмдэгтэд багтаана. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.	Хангалттай Хангалтгүй
	6.	.....	.....	.....
	...	.....	.....	.....

Шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг үнэлэх

Нэгжийн дарга албан хаагчийн сарын ажлын гүйцэтгэлийн тайланг баталгаажуулахын зэрэгцээ үүрэг даалгаврын биелэлтийг “хангалттай”, “хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлэх бөгөөд энэхүү үнэлгээ нь албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхэд хэрэглэгдэнэ.

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажлын биелэлтийг энэ хэсэгт бичнэ.

САРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил

Мэдлэг, ур чадвар	№	Хийх ажлын жагсаалт	Ажлын гүйцэтгэл
Боловсрол, мэргэжил, мэргэшил	1.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
	2.	.....	.....
Удирдан зохион байгуулах, Дүн шинжилгээ хийх Асуудал шийдвэрлэх Манлайлах Бусад	3.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
	4.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухайн сард хийх ажил 1 ажлыг 1000 тэмдэгтэд багтааж төлөвлөнө. Эхлэх, дуусах огноо: 2019.04.01 - 2019.04.25	Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээлэл агуулсан байна. 1 ажлын гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаана.
		.....	.....

Өргөдөл гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлт

Төрийн жинхэнэ албан хаагчид тухайн сард ирсэн өргөдөл гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлтийг энэ хэсэгт бичнэ.

САРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Дөрөв. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

№	Тайлант хугацаа	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1.	2019 оны 04-р сар	....	....	....	....	....	....

Тав. Хариутай бичгийн шийдвэрлэлт

№	Тайлант хугацаа	Ирсэн бичгийн тоо	Шийдвэрлэгдсэн			Шийдвэрлэсэн			Шийдвэрлэсэн хаагаагүй	Шийдвэрлэж хаасан
			Нийт	Хугацаандаа яваа	Хугацаа хэтэрсэн	Нийт	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн		
1.	2019 оны 04-р сар	....	....	....	....	....	....	....	....	....

Нэгжийн дарга №1.

Баталгаажуулсан:

.....

(албан тушаал)

Нэгжийн дарга

.....

(гарын үсэг)

/...../

Төрийн албан хаагч №1.

Тайлагнасан:

.....

(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч

.....

(гарын үсэг)

/...../

Сарын ажлын гүйцэтгэлийн тайлангийн баталгаажуулалт

Нэгжийн дарга (зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын төсвийн шууд захирагч) албан хаагчийн сарын ажлын гүйцэтгэлийн тайланг хянаж, үндэслэлтэй гэж үзвэл гарын үсэг зурж баталгаажуулна.

Нэгжийн дарга хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр журамд заасан хугацаанд албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг дүгнэж, баталгаажуулаагүй тохиолдолд дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж болно.

Мэргэжлийн удирдлагаар хангах, зохих дэмжлэг, чиглэл өгөх

Төлөвлөгөөний биелэлтийн явцын талаарх ярилцлагыг дараа сарын 05-ны дотор хийнэ. Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн сард хийх ажлууд болон шуурхай үүрэг даалгаруудыг хугацаанд нь хийж дуусгасан эсэх?
- Хэрэв хийж дуусгаагүй ажлууд байгаа бол түүний шалтгаан, нөхцлийн талаар ...?
- Дуусгаагүй ажлуудаас ямар ажлыг дараагийн сард үргэлжлүүлэн хийх, ямар ажлыг үргэлжлүүлэх шаардлагагүй талаар ...?
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажлын талаар ...? Ахиц дэвшил гарч буй эсэх?
- Ирсэн өргөдөл, гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хүндрэл гарсан эсэх?
- Албан хаагчийн тухайн сарын ажлын ачааллын талаар ...?
- Байгууллагын удирдлага, нэгжийн дарга болон хамт олны зүгээс ямар туслалцаа дэмжлэг хэрэгтэй эсэх?

Албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн талаар нэгжийн дарга (зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын төсвийн шууд захирагч)-д тогтмол танилцуулж, зохих дэмжлэг, чиглэл авч ажиллана.

УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ

Төрийн жинхэнэ албан хаагчийн улирлын гүйцэтгэлийн тайлан нь 5 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Тайлангийн агуулга

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хэрэгжилт

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах шаардлагад нийцүүлэн энэ хэсэгт тайлагнана. Гүйцэтгэлийн зорилтын үр дүнг 1, 3-р улиралд тайлагнахгүй, 2-р улиралд тайлагнана.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №1.1. Бодлогын баримт бичигийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин													
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1-р арга хэмжээ													
	Уялдав	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	*Хэрэгжих хугацаа*	*Сар*	*1*	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*	*9*	*10*	*11*	*12*
	Шаардагдах хөрөнгө	*Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг бичнэ үү.*												
	Суурь түвшин	*Арга хэмжээ хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга*												
	Шалгуур үзүүлэлт	*Арга хэмжээний үе шат бүрт өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг бичнэ.*												
	Хүрэх түвшин	***...-р улиралд:*** *Арга хэмжээг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга*												
Арга хэмжээний хэрэгжилт	*Хэрэгжилт*	*Гүйцэтгэлийн тайланд даравх асуудлын заавал тусгасан байна.* *- Тухайн арга хэмжээний гүйцэтгэл нь хүрсэн түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх* *- Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах*												
	Зарцуулсан хөрөнгө	*Зарцуулсан мөнгөн дүн, санхүүжилтийн эх үүсвэрийг бичнэ үү.*												
	Хүрсэн түвшин	***...-р улиралд:*** *Хүрсэн тоон болон чанарын утга*												
Нэгжийн дарагын үнэлгээ	*Хангалттай, Хангалтгүй үнэлгээний аль нэгийг сонгоно уу.*													

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх ...-р арга хэмжээ ..... гэх мэт.

Гүйцэтгэлийн зорилт №..... Бодлогын баримт бичигийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт ..... гэх мэт.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №1.1-ийн үр дүн: / Бодлогын баримт бичигийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №1.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....
2.	Шалгуур үзүүлэлт №1.1.2.	.....	.....	.....	.....	.....	.....
...	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Мэдээллийн эх сурвалж: Байгууллагын нэр

Гүйцэтгэлийн зорилт №...-ийн үр дүн: / Бодлогын баримт бичигийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №...	.....	.....	.....	.....	.....	.....
2.	Шалгуур үзүүлэлт №...	.....	.....	.....	.....	.....	.....
...	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Мэдээллийн эх сурвалж: Байгууллагын нэр

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №...-ийн үр дүн: / Бодлогын баримт бичигийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн / ..... гэх мэт.

..... зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилттэй ижил зарчмаар тайлагнана.

УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №2.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ	
	Уялдаа	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №2.1-ийн үр дүн: / Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №2.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №3.1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1-р арга хэмжээ	
	Уялдаа	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БҮЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №3.1-ийн үр дүн: / Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №3.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Гүйцэтгэлийн зорилт №4.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 4.1.1-р арга хэмжээ	
	Уялдаа	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

Гүйцэтгэлийн зорилт №4.1-ийн үр дүн: .....

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №4.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....

ТАВДУГААР ХЭСЭГ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Гүйцэтгэлийн зорилт №5.1. Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан хууль тогтоомжид тусгагдсан төрийн албан тушаалд тавигдах шаардлагуудыг хангах ажиллах

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 5.1.1-р арга хэмжээ	
	Уялдаа	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

Гүйцэтгэлийн зорилт №5.1-ийн үр дүн: .....

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №5.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....

УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Нэгжийн дарга төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэх арга зүйд заасны дагуу албан хаагчийн улирлын гүйцэтгэлийн тайланд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг “хангалттай”, “хангалтгүй” гэсэн үнэлгээгээр тус тус үнэлнэ.

Улирлын гүйцэтгэлийн тайлангийн баталгаажуулалт

Нэгжийн дарга (зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын төсвийн шууд захирагч) албан хаагчийн улирлын гүйцэтгэлийн тайланг хянаж, үндэслэлтэй гэж үзвэл гарын үсэг зурж баталгаажуулна.

Нэгжийн дарга хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр журамд заасан хугацаанд албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлж, баталгаажуулаагүй тохиолдолд дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж болно.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

№	Ажлын төрөл	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ	
				Хангалттай	Хангалтгүй
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн статистик					
1.	Үндсэн чиг үүрэг буюу Дэд салбар №1.	.....	.....	.....	.....
2.	Үндсэн чиг үүрэг буюу Дэд салбар №2. ... гэх мэт.	.....	.....	.....	.....
Хоёр. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн статистик					
1.	Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ	.....	.....	.....	.....
2.	Мэргэжилтэй ажилтанд зориулсан үйлчилгээ	.....	.....	.....	.....
3.	Иргэнд чиглэсэн үйлчилгээ	.....	.....	.....	.....
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн статистик					
1.	Монгол Улсын хууль №...	.....	.....	.....	.....
2.	УИХ-ын тогтоол №...	.....	.....	.....	.....
3.	Засгийн газрын тогтоол №...	.....	.....	.....	.....
Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн статистик					
1.	Төрийн албаны тухай хууль, ...	1	.....	.....	.....
Тав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн статистик					
1.	Төрийн албаны тухай хууль, ...	1	.....	.....	.....

Нэгжийн дарга №1.

Баталгаажуулсан:

.....

(албан тушаал)

Нэгжийн дарга

.....

(гарын үсэг)

.....

(огноо)

/...../

Мэргэжлийн удирдлагаар хангах, зохих дэмжлэг, чиглэл өгөх

Улирлын гүйцэтгэлийн талаарх ярилцлагыг дараа улирлын эхний сарын 05-ны дотор хийнэ. Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн улиралд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн эсэх?
- Хэрэв хийж гүйцэтгээгүй арга хэмжээнүүд байгаа бол түүний шалтгаан, нөхцлийн талаар ...?
- Албан хаагчийн тухайн улирлын ажлын ачааллын талаар ...?
- Байгууллагын удирдлага, нэгжийн дарга болон хамт олны зүгээс ямар туслалцаа дэмжлэг хэрэгтэй эсэх?

Албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн талаар нэгжийн дарга (зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын төсвийн шууд захирагч)-д тогтмол танилцуулж, зохих дэмжлэг, чиглэл авч ажиллана.

ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ

Төрийн жинхэнэ албан хаагчийн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан нь 5 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Тайлангийн агуулга

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хэрэгжилт

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, зорилтын хүрсэн үр дүнг стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах шаардлагад нийцүүлэн энэ хэсэгт тайлагнана.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №1.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин													
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1-р арга хэмжээ													
	Уялдав	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*												
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	*Хэрэгжих хугацаа*	*Сар*	*1*	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*	*9*	*10*	*11*	*12*
	Шаардагдах хөрөнгө	*Санхүүжилтийн эх үүсвэр, тоо хэмжээг бичнэ үү.*												
	Суурь түвшин	*Арга хэмжээ хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга*												
	Шалгуур үзүүлэлт	*Арга хэмжээний үе шат бүрт өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг бичнэ.*												*Хүрсэн эсэх*
	Хүрэх түвшин	***1-р улиралд:*** *Арга хэмжээг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусгахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утга*												*Тийм / Үгүй*
		2-р улиралд: *2-р улиралд хүрэх чанарын болон тоон утга*												*Тийм / Үгүй*
		3-р улиралд: *3-р улиралд хүрэх чанарын болон тоон утга*												*Тийм / Үгүй*
		4-р улиралд: *4-р улиралд хүрэх чанарын болон тоон утга*												*Тийм / Үгүй*
Арга хэмжээний хэрэгжилт	*Хэрэгжилт*	*Гүйцэтгэлийн тайланд даравч асуудлын зааваал тусгасан байна.* *- Тухайн арга хэмжээний үүйцэтгэл нь хүрсэн түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх* *- Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах*												
	Зарцуулсан хөрөнгө	*Зарцуулсан мөнгөн дүн, санхүүжилтийн эх үүсвэрийг бичнэ үү.*												
	Хүрсэн түвшин	***Жилийн эцэст:*** *Хүрсэн тоон болон чанарын утга*												
Нэгжийн даргын үнэлгээ		*Хангалттай, Хангалтгүй үнэлгээний аль нэгийг сонгоно уу.*												

°°°

Арга хэмжээ №....-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Сар	*№*	*Ажил, үйлчилгээний нэр*	*Сар*		
1-р улирал	*1.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*1-р сар*	*2-р сар*	*3-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			
2-р улирал	*2.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*4-р сар*	*5-р сар*	*6-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			
3-р улирал	*3.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*7-р сар*	*8-р сар*	*9-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			
4-р улирал	*4.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*10-р сар*	*11-р сар*	*12-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №1.1-ийн үр дүн: / Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №1.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....
2.	Шалгуур үзүүлэлт №1.1.2.	.....	.....	.....	.....	.....	.....
...	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Мэдээллийн эх сурвалж: Байгууллагын нэр

..... зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэх арга хэмжээний хэрэгжилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, зорилтын хүрсэн үр дүнгүүдийг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилттэй ижил зарчмаар тайлагнана.

ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №2.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ	
	Уялдав	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

Арга хэмжээ №....-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Сар	№	*Ажил, үйлчилгээний нэр*	*Сар*		
1-р улирал	*1.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*1-р сар*	*2-р сар*	*3-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №2.1-ийн үр дүн: / Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №2.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....
2.	Шалгуур үзүүлэлт №2.1.2.	.....	.....	.....	.....	.....	.....

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №3.1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1-р арга хэмжээ	
	Уялдав	*Стратеги төлөвлөгөөний зорилтын дугаар, Хавсралтын дугаар, зорилтын дугаар, ЭЗНХҮЧ-ийн ...-р арга хэмжээ*

Арга хэмжээ №....-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Сар	№	*Ажил, үйлчилгээний нэр*	*Сар*		
1-р улирал	*1.*	*Арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудыг логик дэс дараалалтай, ойлгомжтой, энгийн үг хэллэгээр бичнэ.*	*1-р сар*	*2-р сар*	*3-р сар*
		Гүйцэтгэл: Хийсэн ажлын талаар тодорхой, үнэн зөв ойлголт өгөхөд хангалттай мэдээллийг агуулсан байна.			
	...	.....			

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН НЭР, ДУГААР

Гүйцэтгэлийн зорилт №3.1-ийн үр дүн: / Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын үр дүн /

№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин / Үр дүнгийн үзүүлэлт			
				2019 оны эхний хагаст		2019 оны жилийн эцэст	
			2018 он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1.	Шалгуур үзүүлэлт №3.1.1.	.....	.....	.....	.....	.....	.....
2.	Шалгуур үзүүлэлт №3.1.2.	.....	.....	.....	.....	.....	.....

ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Гүйцэтгэлийн зорилт №4.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин	
